



ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны
хурлын төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1, 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, "Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны хурлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Уянга/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ШИНЭХҮҮ

“Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 22 өдрийн 04 дугаар тогтоолын хавсралт



“ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ” ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ХУРЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хуралд танилцуулах нэгж	Гарах шийдвэр
1	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөө батлах	1 дүгээр сар	ТУЗ-ийн дарга	Тогтоол
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах	1 дүгээр сар	ТУЗ-ийн дарга	Тогтоол
3	Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг чөлөөлөх; томилох	1 дүгээр сар	Гүйцэтгэх захирал	Тогтоол
4	Компанийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцэх	1 дүгээр сар	Гүйцэтгэх захирал	Тэмдэглэл
5	Компанийн 2023 оны үйл ажиллагаа, 2024 оны төлөвлөгөөтэй танилцах	1 дүгээр сар	Гүйцэтгэх захирал	
6	Засгийн газрын 2023 оны 483-р тогтоолын ТОСК ТӨХХК-д хамаарагдах заалтын хүрээнд холбогдох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх	2 дугаар сар	Гүйцэтгэх захирал	Тэмдэглэл
7	Компанийн 2023 санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн тухай хэлэлцэх	3 дугаар сар	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	Тогтоол
8	Ногдол ашиг хуваарилах эсэх тухай хэлэлцэх	3 дугаар сар	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	Тогтоол
9	Гүйцэтгэх захиралтай байгуулсан 2023 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэх	3 дугаар сар	Санхүү, хөрөнгө оруулалтын газар, Захиргаа удирдлагын газар	Тогтоол
10	Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн дэргэдэх дэд хороодын ажиллах журам шинэчлэн батлах	3 дугаар сар	ТУЗ-ийн дарга	Тогтоол
11	ТОСК ТӨХХК-ийн хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр болон эзэмшиж буй газрын мэдээлэлтэй танилцах	4 дүгээр сар	Төслийн хэрэгжилтийн газар	
12	Компанийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийн явцыг хэлэлцэх	4 дүгээр сар	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	Тэмдэглэл
13	Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийн хэсэгт барилгын тухай хуулийн 42.1, 42.1.6, 42.1.7, 42.1.8-д	4 дүгээр сар	Хууль, эрх зүй, дотоод хяналтын газар	Тогтоол

	заасан үйл ажиллагааг шинээр бүртгүүлэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх			
14	“Эко Яармаг-1” төслийн талбайд газраа чөлөөгүй байгаа 3 нэгж талбарын иргэдийн асуудлыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэх	4 дүгээр сар	Төслийн хэрэгжилтийн газар	Тэмдэглэл
15	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэх	5 дугаар сар	Гүйцэтгэх захирал	Тэмдэглэл
16	Хөгжлийн банкны бондын өр төлбөрийн эргэн төлөлтийн талаарх мэдээлэлтэй танилцах	5 дугаар сар	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	Тэмдэглэл
17	Засгийн газрын 2023 оны 483 дугаар тогтоолын хэрэгжилтийг хэлэлцэх	5 дугаар сар	Гүйцэтгэх захирал	Тэмдэглэл
18	Дуусаагүй 400 авто машины зогсоолын барилгын ажлын гүйцэтгэл болон Си Эйч Си ХХК-тай тендерт ирүүлсэн төсөв нь батлагдсан ажлын зургаас зөрүүтэй байгаа зэрэг алдаа дутагдлыг мэргэжлийн хяналтын ерөнхий газраас (тухайн үеийн) ирүүлсэн чиглэлийн дагуу цаашид авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэр гаргах	5 дугаар сар	Хөрөнгийн ашиглалт, зохицуулалтын газар	Тэмдэглэл
19	“Буянт-ухаа 1” хорооллын борлогдоогүй 6 авто зогсоолын орж гарахад нь орц гарц нь хязгаарлагдмал авто зогсоолыг худалдан борлуулах эсэх шийдвэр гаргах	5 дугаар сар	Хөрөнгийн ашиглалт, зохицуулалтын газар	Тогтоол
20	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй хөрөнгийг актлах тухай хэлэлцэх	6 дугаар сар	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	Тогтоол
21	Компанийн 2024 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийх асуудлыг хэлэлцэх	6 дугаар сар	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	Тогтоол
22	Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх 2024 оны төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцэх	8 дугаар сар	Дотоод аудитор	Тэмдэглэл
23	Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийн явцтай танилцах	8 дугаар сар	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	Тэмдэглэл
24	Хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж буй өр, авлагын асуудлыг хэлэлцэх	9 дүгээр сар	Захиргаа, удирдлагын газар	Тэмдэглэл
25	Хөгжлийн банкны бондын өр төлбөрийн эргэн төлөлтийн талаарх мэдээлэлтэй танилцах	9 дүгээр сар	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	Тэмдэглэл
26	ТОСК ТӨХХК-ийн хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах	9 дүгээр сар	Төслийн хэрэгжилтийн газар	
27	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэх	9 дүгээр сар	Гүйцэтгэх захирал	Тэмдэглэл

28	Хөгжлийн банкны бондын өр төлбөрийн эргэн төлөлтийн талаарх мэдээлэлтэй танилцах	9 дүгээр сар	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	Тэмдэглэл
29	Засгийн газрын 2023 оны 483 дугаар тогтоолын хэрэгжилтийг хэлэлцэх	9 дүгээр сар	Гүйцэтгэх захирал	Тэмдэглэл
30	Компанийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийн явцыг хэлэлцэх	10 дугаар сард	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	Тэмдэглэл
31	Компанийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг хэлэлцэх	10 дугаар сард	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	Тогтоол
32	Компанийн 2024 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусгасан үр дүнгийн урамшууллыг олгох асуудлыг хэлэлцэх	12 дугаар сард	Санхүү, хөрөнгө оруулалтын газар, Захиргаа, удирдлагын газар	Тогтоол
33	Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан тогтоолын хэрэгжилтийг хэлэлцэх	12 дугаар сард	ТУЗ-ийн дарга	Тэмдэглэл
34	Цаг үеийн холбогдолтой бусад асуудал хэлэлцэх	Тухай бүр	Гүйцэтгэх захирал	Тогтоол, тэмдэглэл